



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сайншанд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор:
Цахим хаяг:
Утас:
Аудитын менежер:
Цахим хаяг:
Утас:
Ахлах аудитор:
Цахим хаяг:
Утас:
Аудитор :

Т.Ган-Өлзий
gan-ulziit@audit.gov.mn
70522734
У.Оюунтүлхүүр
oyuntulkhuur.u@audit.gov.mn
70523020
Д.Сайнжаргал
info.iedca@gmail.com
99080493
Б.Болормаа



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.24 № 1-6/84

танай _____-ны № _____-т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН
ЗУРГААДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.ЦЭЦЭГДЭЛГЭР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Хүүхдийн зургаадугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь тендер шалгаруулалтын явцад оролцогчоос санал болгосон бараа, ажил, үйлчилгээ нь тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн тодорхойлолт, шаардлагад бүрэн нийцсэн эсэхийг хангалттай нягтлан шалгаагүй, үнэлгээ хийх явцад холбогдох баримт бичиг, нотолгоог бүрэн бүрдүүлээгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль,

442505047

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	220,918,044.19	153,790,905.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	148,871,255.75	48,307,374.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	148,871,255.75	48,307,374.18
3121	Төгрөг	148,871,255.75	48,307,374.18
31211	Төрийн сангийн харилцах	148,871,255.75	48,307,374.18
35	БАРАА МАТЕРИАЛ	72,046,788.44	105,483,531.44
351	Түүхий эд материал	17,783,210.00	38,043,060.00
35110	Тусгай зориулалттай материал	17,561,210.00	37,989,060.00
35130	Эм боох материал	222,000.00	54,000.00
354	Хангамжийн материал	54,263,578.44	67,440,471.44
35410	Бичиг хэргийн материал	3,321,430.00	4,474,180.00
35420	Аж ахуйн материал	33,297,194.44	54,158,094.44
35450	Барилгын засварын материал	620,000.00	467,400.00
35460	Хүнсний материал	17,007,554.00	8,223,497.00
35470	Бусад хангамжийн материал	17,400.00	117,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	965,655,687.07	980,994,174.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	965,655,687.07	980,994,174.46
392	Биет хөрөнгө	913,408,175.35	929,031,195.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	921,388,166.00	921,388,166.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,813,440.20)	(78,976,128.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,343,576.00	65,721,282.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,214,555.55)	(19,135,120.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,597,628.00	57,258,172.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,137,389.75)	(22,004,707.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,439,961.00	8,753,961.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,195,770.15)	(3,974,429.19)
393	Биет бус хөрөнгө	52,247,511.72	51,962,978.48
39301	Программ хангамж	2,202,500.00	2,202,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,034,308.28)	(1,318,841.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,079,320.00	51,079,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,186,573,731.26	1,134,785,080.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	861,650.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	861,650.00
413	Өглөг	-	861,650.00
4136	Бусад өглөг	-	861,650.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	861,650.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,186,573,731.26	1,133,923,430.08
51	Засгийн газрын хувь оролцоо	1,186,573,731.26	1,133,923,430.08
512	Хуримтлагдсан үр дүн	1,186,573,731.26	1,133,923,430.08
51210	Өмнөх үеийн үр дүн	1,186,573,731.26	1,186,573,731.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	(52,650,301.18)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,186,573,731.26	1,134,785,080.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	642,915,013.98	732,476,246.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,570,000.00	94,246,846.20
120	Нийтлэг татварын бус орлого	19,570,000.00	94,246,846.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,570,000.00	24,362,750.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,570,000.00	24,362,750.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		51,320,636.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		18,563,460.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	623,345,013.98	638,229,400.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,080,200.00	568,514,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,080,200.00	568,514,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,264,813.98	69,715,100.30
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,264,813.98	69,715,100.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	649,679,606.29	785,126,547.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	649,679,606.29	785,126,547.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,179,606.29	785,126,547.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,805,571.47	542,443,012.40
210101	Үндсэн цалин	309,549,627.04	340,949,087.15
210102	Нэмэгдэл	102,996,344.43	162,290,845.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	30,936,000.00
210104	Урамшуулал	8,259,600.00	8,267,080.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,550,792.22	65,943,019.17
210201	Тэтгэврийн даатгал	35,719,645.44	45,162,826.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,120,353.81	5,322,727.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,027,176.88	2,661,366.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,874,294.36	2,511,731.35
210205	Эрүүл мэндийн даатгал	7,809,321.73	10,284,367.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,264,813.98	66,715,100.30
210301	Гэрэл, цахилгаан	7,150,365.25	8,718,893.90
210302	Түлш, халаалт	34,890,020.00	46,415,701.20
210303	Цэвэр, бохир ус	5,224,428.73	11,580,505.20
2104	Хангамж, бараа материалын зардал	12,176,350.00	5,981,260.00
210401	Бичиг хэрэг	1,636,450.00	1,019,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,364,265.00	1,107,750.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	91,000.00
210408	Бараа материал акталсны зардал	7,175,635.00	3,762,760.00
2105	Нормативт зардал	49,952,796.10	55,478,607.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,249,000.00	1,730,550.00
210502	Хоол, хүнс	48,703,796.10	53,748,057.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,066,900.00
210604	Урсгал засвар	-	2,066,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960,000.00	1,184,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	960,000.00	1,184,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,469,282.52	45,314,648.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,237,000.00	7,667,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	165,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,232,282.52	37,482,148.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,764,592.31)	(52,650,301.18)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,764,592.31)	(52,650,301.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>642,915,013.98</u>	<u>662,592,150.30</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,570,000.00	24,362,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,570,000.00	24,362,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,570,000.00	24,362,750.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,570,000.00	24,362,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	623,345,013.98	638,229,400.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,080,200.00	568,514,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,080,200.00	568,514,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,264,813.98	69,715,100.30
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,264,813.98	69,715,100.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>615,699,671.17</u>	<u>761,656,031.87</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,699,671.17	761,656,031.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596,199,671.17	761,656,031.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,805,841.47	542,443,012.41
210101	Үндсэн цалин	309,549,897.04	342,374,638.51
210102	Нэмэгдэл	102,996,344.43	160,992,745.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	30,872,000.00
210104	Урамшуулал	8,259,600.00	8,203,628.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,550,792.22	65,943,019.16
210201	Тэтгэврийн даатгал	35,719,645.44	45,150,854.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,120,353.81	5,322,732.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,027,176.88	2,661,366.29
210204	Ажилгүйдлийн даатгал	1,874,294.36	2,523,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,809,321.73	10,284,366.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,264,813.98	66,715,100.30
210301	Гэрэл, цахилгаан	7,150,365.25	8,718,893.90
210302	Түлш, халаалт	34,890,020.00	53,651,426.40
210303	Цэвэр, бохир ус	5,224,428.73	4,344,780.00
2105	Нормативт зардал	54,099,323.50	44,984,400.00
210502	Хоол, хүнс	54,099,323.50	44,984,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960,000.00	1,184,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	960,000.00	1,184,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,518,900.00	37,386,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,983,100.00	32,838,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,535,800.00	4,548,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,215,342.81</u>	<u>(99,063,881.57)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,831,000.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,831,000.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,831,000.00	1,500,000.00
223001	Бусад хөрөнгө	2,831,000.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,831,000.00)</u>	<u>(1,500,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,384,342.81	(100,563,881.57)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		148,871,255.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	148,871,255.75	48,307,374.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,179,809,138.95	1,179,809,138.95
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,179,809,138.95	1,179,809,138.95
3	Тайлант үеийн үр дүн	-	-	6,764,592.31	6,764,592.31
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,186,573,731.26	1,186,573,731.26
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	1,186,573,731.26	1,186,573,731.26
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,186,573,731.26	1,186,573,731.26
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(52,650,301.18)	(52,650,301.18)
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	1,133,923,430.08	1,133,923,430.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	828,352,300.00	662,592,150.30	165,760,149.70	80%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	573,468,000.00	568,514,300.00	4,953,700.00	99%
131001	Улсын төсвөөс санхүүжих	573,468,000.00	568,514,300.00	4,953,700.00	99%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,319,700.00	69,715,100.30	604,599.70	99%
132001	Орон нутгийн төсвөөс	70,319,700.00	69,715,100.30	604,599.70	99%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	184,564,600.00	24,362,750.00	160,201,850.00	13%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,829,500.00	24,362,750.00	28,466,750.00	46%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	131,735,100.00	-	131,735,100.00	0%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	828,352,300.00	763,156,031.87	65,196,268.13	92%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	828,352,300.00	763,156,031.87	65,196,268.13	92%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	808,752,300.00	763,156,031.87	45,596,268.13	94%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,286,900.00	542,443,012.41	9,843,887.59	98%
210101	Үндсэн цалин	343,147,600.00	342,374,638.51	772,961.49	100%
210102	Нэмэгдэл	194,687,400.00	160,992,745.20	33,694,654.80	83%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	30,872,000.00	(30,872,000.00)	
210104	Урамшуулал	14,451,900.00	8,203,628.70	6,248,271.30	57%

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,637,200.00	65,943,019.16	2,694,180.84	96%
210201	Тэтгэврийн даатгал	46,545,800.00	45,150,854.08	1,394,945.92	97%
210202	Тэтгэмжийн даатгал	5,522,900.00	5,322,732.15	200,167.85	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,761,400.00	2,661,366.29	100,033.71	96%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,761,400.00	2,523,700.00	237,700.00	91%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,045,700.00	10,284,366.64	761,333.36	93%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,319,700.00	66,715,100.30	604,599.70	99%
210301	Гэрэл, цахилгаан	8,692,500.00	8,718,893.90	(26,393.90)	100%
210302	Түлш, халаалт	54,396,000.00	53,651,426.40	744,573.60	99%
210303	Цэвэр, бохир ус	4,231,200.00	4,344,780.00	(113,580.00)	103%
2105	Нормативт зардал	69,517,500.00	44,984,400.00	24,533,100.00	65%
210502	Хоол, хүнс	69,517,500.00	44,984,400.00	24,533,100.00	65%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,771,100.00	1,184,000.00	2,587,100.00	31%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,771,100.00	1,184,000.00	2,587,100.00	31%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,219,900.00	38,886,500.00	5,333,400.00	88%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,767,400.00	34,338,100.00	3,429,300.00	91%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,452,500.00	4,548,400.00	1,904,100.00	70%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		148,871,255.75	(148,871,255.75)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,307,374.18	(48,307,374.18)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 170.2 сая төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 170.2 сая төгрөгийн 4 алдааг бүрэн залруулсан.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд 18.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал дансны орлогыг зөрүүтэй бүртгэснээс Санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулагдаагүй байна.
2. Тайлант онд 51.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгийн дансны орлогыг зөрүүтэй бүртгэснээс Санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулагдаагүй байна.
3. Дахин үнэлсэн үндсэн машин тоног төхөөрөмжийг хөрөнгийн данснаас хасахдаа хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнээс 30.0 сая төгрөгийн илүү дүнгээр хассан байна.
4. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт 70.3 сая төгрөгийг дутуу тайлагнасан байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай нийцээгүй тул залруулсан.

Аудитаар 45.8 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаарх бусад нийт 0.8 сая төгрөгийн зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 9.7 сая төгрөгөөс бага байгаа тул “**ӨӨРЧЛӨЛТГҮЙ**” дүгнэлт өглөө.

3.1. Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2. Албан шаардлага:

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

3.3. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Цэцэрлэгийн барилга 2018 онд ашиглалтад орсон ба Боловсрол, шинжлэх ухааны сайдын (хуучин нэршлээр) 2021.01.26 өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т барилга байгууламж, орон сууцны элэгдэл тооцох хугацааг 50 жилээр заасан боловч нягтлан бодох бүртгэлд 70 жилээр тооцож элэгдэл байгуулж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаатай тохирохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1-т “*анхан шатны баримт нь нягтлан бодох*

бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид үндсэн хөрөнгийн элэгдлийн ашиглах жилийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу тусгах

2. Өглөгтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд 0.8 сая төгрөгийн ариутгалын төлбөрийн өглөг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийг зохистой удирдаж, өглөг үүсгэхгүй байх, өглөг үүссэн тохиолдолд тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

3. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Захиалагч нь худалдан авах ажиллагаанд оролцогч ирээгүй нөхцөлд шалтгааныг судалж, дахин зохион байгуулах эсэх талаар шийдвэр гаргалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т *“энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 10 дугаар зүйлийн 10.2-т “энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 25 дугаар зүйлийн 25.5-т “тендерийн талаар тодруулга авах захиалагчийн хүсэлтэд заасан хугацааны дотор оролцогч хариу ирүүлээгүй нь хянан үзэх, үнэлэх ажиллагааг хойшлуулах үндэслэл болохгүй”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид худалдан авах ажиллагаанд оролцогч материал ирүүлээгүй тохиолдолд нөхцөл шалтгааныг судалж, дахин зохион байгуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 3 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулсан аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орлого, үр дүнгийн тайланд Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал данс толилуулагдаагүй	1	18.6	1	18.6			1	18.6	-	-	-	-
Орлого, үр дүнгийн тайланд Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө данс толилуулагдаагүй	1	51.3	1	51.3			1	51.3	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг илүү бүртгэсэн	1	30.0			1	30.0	1	30.0	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт буруу тайлагнасан	1	70.3			1	70.3	1	70.3	-	-	-	-
Дүн	4	170.2	2	69.9	2	100.3	4	170.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан тушаал шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Өглөг үүсгэсэн	1	0.8	-	-	-	-	1	0.8	-	-	-	-
НБББББ-т заасны дагуу ашиглах хугацаанд элэгдүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	0.8	-	-	-	-	2	0.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй	1	44.9	-	-	-	-	1	44.9
Дүн	1	44.9	-	-	-	-	1	44.9
Нийт дүн	1	44.9					1	44.9